

Японы хилээр нэвтрэх, оршин суух бүртгэл



1

Оршин суугчийн үнэмлэх

Оршин суугчийн үнэмлэх нь Япон улсад оршин суугаа гадаад иргэний үнэмлэх юм. Тухайн хүний хувийн мэдээлэл болон Японд байхыг зөвшөөрсөн хугацаа (оршин суух хугацаа), Японд хийж болох үйл ажиллагаа (оршин суух зөвшөөрөл) зэргийг бичсэн байдаг.



- 16-аас дээш насны хүн биедээ байнга авч явах хэрэгтэй.
- Энэхүү үнэмлэхийг мөн Хот, дүүрэг, орон нутгийн захиргаанд аливаа бүрдүүлэлт хийх болон гэрээ байгуулах зэрэгт иргэний үнэмлэх болгон ашиглах боломжтой. болон гэрээ байгуулах зэрэг албан бичиг бүрдүүлэхэд шаардлагатай үнэмлэх болдог.

Оршин суугчийн үнэмлэх авах боломжтой хүн

Оршин суугчийн үнэмлэх нь 3-аас дээш сарын хугацаагаар Японд оршин суух гадаад хүнд олгогддог. (Оршин суух үнэмлэх авах боломж бүхий ийм хүнийг “Дунд, урт хугацааны оршин суугч” гэж нэрлэдэг.)

"Оршин суугчийн үнэмлэх олгогдохгүй байх 6 тохиолдол"

- ① Оршин суух хугацаа нь “3 сар”-аас бага хүн
- ② Оршин суух зөвшөөрөл нь “Богино хугацаагаар оршин суух” хүн
- ③ Оршин суух зөвшөөрөл нь “Дипломат” болон “Албан” зорилгоор оршин суух хүн
- ④ Оршин суух зөвшөөрөл нь “Тусгай үйл ажиллагаа”-ны дараах аль нэг төрөлд хамаарах хүн
 - Тайвань-Японы харилцааны нийгэмлэгийн Япон Улс дахь төлөөлөгчийн газар (Япон Улсад суугаа Тайпэйгийн эдийн засаг,соёлын төлөөлөгчийн газар гэх зэрэг)-ын ажилтан болон түүний гэр бүлийн гишүүд
 - Япон Улс дахь Палестины байнгын төлөөлөгчийн газрын ажилтан болон түүний гэр бүлийн гишүүд
 - Дижитал номад (Олон Улсын зайнаас ажиллах зорилгоор Япон Улсад түр оршин суугаа хүн гэх мэт) болон түүний эхнэр/нөхөр, хүүхдүүд
- ⑤ Тусгай байнгын оршин суугч
- ⑥ Оршин суух зөвшөөрөлгүй хүн

1-1

Оршин суух үнэмлэх олгох

Оршин суух үнэмлэхийг дараах тохиолдолд олгоно.

- ① **Шинээр газардах зөвшөөрөл авч, Нарита, Ханэда, Чюүбү, Кансай, Шинчитосэ, Хирошима, Фукуока нисэх онгоцны буудлаар тус тус хил нэвтрэх үед**
➔ Нисэх онгоцны буудал дээр оршин суугчийн үнэмлэхийг олгоно.
- ② **Шинээр газардах зөвшөөрөл авч, ①-ээс бусад нисэх онгоцны буудал болон усан боомтоор хил нэвтрэх үед**
➔ Японы Улсад нэвтэрсний дараа оршин суух хаягийн харьяа хот, дүүрэг, орон нутгийн захиргаанд “Оршин суух хаягийн бүртгэл (Шилжин суурьших мэдэгдэл)” хийлгэнэ үү. Бүртгүүлсний дараа таны Оршин суух үнэмлэх шуудангаар гэрт тань хүргэгдэнэ.
- ③ **Оршин суух хугацааг өөрчлөх зөвшөөрөл авсан тохиолдолд**
➔ Оршин суух хугацаа дуусгавар болохоос өмнө тухайн орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газар (2.1-ээс үзнэ үү)-т оршин суух хугацаа сунгуулах хүсэлтээ гаргана уу.
- ④ **Оршин суух зөвшөөрлийн төрөл солих**
➔ Япон улсад оршин суух зорилго өөрчлөгдсөн тохиолдолд, орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт оршин суух зөвшөөрлийн төрөл солих хүсэлт (2.2-оос үзнэ үү) гаргаж, зөвшөөрөгдсөн тохиолдолд шинээр оршин суух үнэмлэх олгогдоно.
- ⑤ **Оршин суух зөвшөөрөл шинээр авах**
➔ Японд төрсөн хүүхэд Японы иргэншилгүй байх тохиолдолд төрснөөс хойш 60-аас дээш хоног үргэлжлүүлэн Японд оршин суух бол, төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт оршин суух зөвшөөрөл авах хүсэлт (2.4-өөс үзнэ үү) гаргаж, зөвшөөрөгдсөн тохиолдолд шинээр оршин суух үнэмлэх олгогдоно.

1-2

Оршин суух хаягийн бүртгэл хийлгэх (Шилжилт хөдөлгөөний бүртгэл)

Оршин суух үнэмлэх авсан хүн, амьдрах газар (амьдарч буй газар, бүртгүүлэх хаяг)-аа шийдсэнээс 14 хоногийн дотор, амьдарч буй хот, дүүрэг, орон нутгийн захиргааны нэгжид хандан хаягийн бүртгэл (шилжилт хөдөлгөөний бүртгэл) хийлгэх шаардлагатай.

Бүртгэл хийлгэх үед оршин суух үнэмлэх (1.1-ийн ① байх тохиолдолд) эсвэл гадаад паспорт (1.1-ийн ② байх тохиолдолд) хэрэгтэй учир марталгүй авч очно уу.

2-р бүлгийн 1 1.1 хаягийн шилжүүлгээс харна уу.

1-3

Оршин суух үнэмлэхээ хаяж гээгдүүлсэн тохиолдолд

Оршин суух үнэмлэхээ гээгдүүлснээ мэдсэнээс хойш 14 хоногийн дотор орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт хандан оршин суух үнэмлэх дахин олгох хүсэлт гаргана.

Хүсэлт гаргахад шаардлагатай материал

- Гадаад паспорт
- Цээж зураг 1 хувь (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан байх өндөр 4×3 см хэмжээтэй цээж зураг. 16 нас хүрээгүй бол шаардлагагүй)
- Оршин суух үнэмлэх хаяж гээгдүүлсэн бичиг баримт (Хаяж гээгдүүлсэн зүйлийн бүртгэлийн бичиг, хулгайд алдсан магадлагаа бичиг, гамшигт нэрвэгдэн хохирол авсныг нотлох бичиг зэрэг)
- Оршин суух үнэмлэх дахин олгохыг хүссэн өргөдөл

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас үзнэ үү.

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/nyuukokukanri10_00010.html



1-4

Оршин суух үнэмлэхээ хураалгах

Дараах тохиолдолд оршин суугчийн үнэмлэхээ орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт буцааж өгөх шаардлагатай.

Энгийнээр нутаг буцах

(Япон дахь үйл ажиллагаа дуусан хилээр гарах үед)

- Хилээр гарах үедээ нисэх онгоцны буудал болон усан боомтын хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтанд буцааж өгнө үү.

- Гэр бүл болон хамт амьдарч байгаа хүн нас барсан тохиолдолд
- (Тусгай) Японд дахин нэвтрэх зөвшөөрөлтэйгээр хилээр гарч, (тусгай) Японд нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаандаа буцаж орж ирээгүй тохиолдолд
- Японы иргэншил авсан тохиолдолд

Дараах аль нэг аргаар 14 хоногийн дотор буцааж өгнө үү.

- Ойролцоох орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт авч очих
- Шуудангаар дараах хаяг руу илгээх

Илгээх хаяг: 〒135-0064 Tokyo-to Koto-ku Aomi 2-7-11

Tokyo Port Joint Government Office 9th

Floor, Online Inspection Department Odaiba Branch Office,

Tokyo Regional Immigration Services Bureau

(Дугтуй дээр「在留カード返納」(Оршин суугчийн үнэмлэх буцаах) гэж бичнэ үү



Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас үзнэ үү.

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/nyuukokukanri10_00020.html



2

Оршин суух зөвшөөрөлтэй холбоотой бүртгэлүүд

2-1

Оршин суух хугацааг сунгах (оршин суух хугацааг сунгахыг хүссэн тохиолдолд)

Зөвшөөрөл авсан оршин суух хугацаанаас илүү хугацаагаар үргэлжлүүлэн Япон улсад оршин суух хүсэлтэй бол орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт оршин суух хугацаа сунгах хүсэлт гаргах шаардлагатай.



Хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримт

- Гадаад паспорт
- Оршин суух үнэмлэх (үнэмлэх авсан тохиолдолд)
- Цээж зураг 1 хувь (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан байх 4×3 см хэмжээтэй цээж зураг. 16 нас хүрээгүй бол шаардлагагүй.)
- Оршин суух хугацаа сунгуулах өргөдлийн маягт болон төлөвлөж буй үйл ажиллагааг тодорхойлох материалууд бүрдүүлнэ үү.

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-3.html>



2-2

Оршин суух зөвшөөрлийн статус өөрчлөх (Японд оршин суух зорилгоо өөрчлөх тохиолдолд)

Одоогийн оршин суух зорилгоо өөрчлөн оршин суухыг хүссэн тохиолдолд, орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт оршин суух зөвшөөрлийн статус өөрчлөх хүсэлт гаргах шаардлагатай.



Хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримт

- Гадаад паспорт
- Оршин суугчийн үнэмлэх (үнэмлэх авсан тохиолдолд)
- Цээж зураг 1 хувь (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан байх 4×3 см хэмжээтэй цээж зураг. 16 нас хүрээгүй бол шаардлагагүй.)
- Оршин суух зөвшөөрлийн статус өөрчлөх өргөдлийн маягт болон төлөвлөж буй үйл ажиллагааг тодорхойлох материалууд бүрдүүлнэ үү.

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-2.html>



○Оршин суух зөвшөөрлийн статусаар хайх○

<https://www.moj.go.jp/isa/applications/status/index.html>



2-3

Байнгын оршин суух зөвшөөрөл

Японд байнга оршин суух хүн байнгын оршин суугчийн зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах шаардлагатай. Байнгын оршин суух зөвшөөрөл олгогдсон бол Японд ямар үйл ажиллагаа эрхэлж, хүссэн хугацаандаа Японд үлдэх боломжтой болж, оршин суух хугацааг сунгах, солих шаардлагагүй болно.

Хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримт

- Гадаад паспорт
- Оршин суух үнэмлэх
- Цээж зураг 1 хувь (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан байх 4×3 см хэмжээтэй цээж зураг. 16 нас хүрээгүй бол шаардлагагүй.)
- Байнгын оршин суугчийн зөвшөөрөл хүсэх өргөдөл
- Бусад шаардлагатай материал

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-4.html>



2-4

Оршин суух зөвшөөрөл авах (хүүхэд төрсөн тохиолдолд)

Японд төрсөн хүүхэд Японы иргэншилгүй тохиолдолд, төрсний дараа 60-аас дээш хоног үргэлжлүүлэн Японд оршин суухыг хүсвэл, төрснөөс хойш 30 хоногийн дотор харьяа орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагатай.

* Доор тайлбарлах “Төрсний бүртгэлийн гэрчилгээ” болон бусад бичиг баримт шаардлагатай тул урьдчилан хот, дүүрэг, орон нутгийн захиргаанд төрсний бүртгэл хийлгэсний дараа тухайн орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт энэ бүртгэлийг хийлгэнэ үү.

4-р бүлгийн 2 2.1 төрсний бүртгэл хэсгээс үзнэ үү.

Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримт

- Гадаад паспорт (авсан тохиолдолд)
- Оршин суух зөвшөөрөл авах өргөдөл
- Төрсний гэрчилгээ (хот, дүүрэг, орон нутгийн захиргаанаас авна) болон бусад төрснийг батлах бичиг баримт
- Төлөвлөж буй үйл ажиллагааны агуулгыг тодорхойлох материал
<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-10.html>
- Япон дахь оршин суух тодорхойлолт эсвэл оршин суугчийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий тодорхойлолт (Хот дүүрэг, орон нутгийн захиргааны нэгжээс авна)



2-5

Оршин суух зөвшөөрлөөс гадуур үйл ажиллагаа явуулах эрх

Хөдөлмөр эрхлэх боломжгүй оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн (оюутан, гэр бүлийн статусаар оршин суугч гэх мэт) болон оршин суух зөвшөөрөл дээр заасан хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанаас гадуур ажилхийж орлого олох, цалин авах гэж буй тохиолдолд, орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт хүсэлт гаргаж, оршин суух зөвшөөрлөөс гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах шаардлагатай. (Өөрийн оршин суух зөвшөөрлөөр ямар ажил эрхлэх боломжтойг 3-р бүлгийн 1 1.1 оршин суух зөвшөөрөл хэсгээс үзнэ үү.)

Хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримт

- Гадаад паспорт
- Оршин суух үнэмлэх
- Оршин суух зөвшөөрлөөс гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүсэх өргөдөл
- Орлого олох, цалин авахаар төлөвлөж буй үйл ажиллагааг тодорхойлох бичиг баримт



Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-8.html>



2-6

Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт бүртгүүлэх

Оршин суух үнэмлэхтэй гадаад иргэд дотор дараах оршин суух зөвшөөрөл бүхий хүн нь харьяа байгууллагаа өөрчилсөн тохиолдолд орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт бүртгүүлэх шаардлагатай.

(1) Үйл ажиллагаа явуулж буй байгууллагатай холбоотой бүртгэл

Хамаарал бүхий оршин суух зөвшөөрөл	Профессор, өндөр зэрэглэлийн мэргэжилтэн Дугаар 1-ийн ха(/ \), өндөр зэрэглэлийн мэргэжилтэн Дугаар 2 (Дугаар 2-ын ха(/ \) ангилалд хамаарагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд), бизнесийн удирдлага-менежмент, хууль, нягтлан бодох бүртгэл, эмчилгээ, боловсрол, албан байгууллагын дотоод томилолт, ур чадварын дадлагажигч, оюутан, дадлагажигч
Хамрагдах бүртгэлийн агуулга	• Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын нэр өөрчлөгдсөн тохиолдолд • Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд • Үйл ажиллагаа явуулж буй байгууллага татан буугдсан тохиолдолд • Үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас гарсан тохиолдолд • Үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас шилжсэн тохиолдолд
Бүртгэл хийх хугацаа	14 хоногийн дотор бүртгүүлнэ үү.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/nyuukokukanri10_00014.html



(2) Гэрээт байгууллагатай холбоотой мэдэгдэл

Хамаарал бүхий оршин суух зөвшөөрөл	Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн Дугаар 1-ийн и(ㄱ), өндөр зэрэглэлийн мэргэжилтэн Дугаар 1-ийн ро(ㄹ), өндөр зэрэглэлийн мэргэжилтэн Дугаар 2 (Дугаар 2-ын и(ㄱ) эсвэл ро(ㄹ) ангилалд хамаарагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд), судлаач, инженер, хүмүүнлэгийн мэргэжилтэн, олон улсын үйлчилгээ, асаргаа, урлаг спорт (зөвхөн Япон улсын төрийн болон хувийн байгууллагатай хийсэн гэрээнд үндэслэн үйл ажиллагаа явуулах тохиолдолд) ур чадвар, тусгай ур чадвартай ажилтан
Хамрагдах бүртгэлийн агуулга	- Гэрээ байгуулсан байгууллагын нэр өөрчлөгдсөн тохиолдолд - Гэрээ байгуулсан байгууллагын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд - Гэрээ байгуулсан байгууллага татан буугдсан тохиолдолд - Гэрээ дуусгавар болсон тохиолдолд - Гэрээ байгуулсан байгууллагатай шинэ гэрээ байгуулсан тохиолдолд
Бүртгэлд хамрагдах хугацаа	14 хоногийн дотор бүртгүүлнэ үү.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/nyuukokukanri10_00015.html



(3) Эхнэр болон нөхөртэй холбоотой бүртгэл

Хамаарал бүхий оршин суух зөвшөөрөл	Гэр бүлээр оршин суух, Япон хүний гэр бүл зэрэг байнгын оршин суугчийн гэр бүл гэсэн оршин суух зөвшөөрөлтэй хүн
Хамрагдах бүртгэлийн агуулга	- Гэр бүлийн хүнээс салсан тохиолдолд - Гэр бүлийн хэн нэг нь нас барсан тохиолдолд
Бүртгэл хийх хугацаа	14 хоногийн дотор бүртгүүлнэ үү.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/nyuukokukanri10_00016.html



Эдгээр бүртгэлийг өөрийн биеэр авчрах болон шуудангаар илгээхээс гаднаинтернэт ашиглан цахим хэлбэрээр мөн хийх боломжтой.

Цахим хэлбэрээр бүртгүүлэх дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

https://www.moj.go.jp/isa/publications/materials/i-ens_index.html



ONE POINT

Өндөр түвшний гадаадын ур чадвартай мэргэжилтнүүдэд давуу эрх олгох

Японы эдийн засгийн өсөлт зэрэгт өөрийн хувь нэмрээ оруулж чадах өндөр ур чадвар эзэмшсэн гадаадын иргэн нь Японд явуулж болох үйл ажиллагааны агуулга болон оршин суух хугацааны давуу эрх эдэлдэг.

Тухайн үйл ажиллагааны онцлогоос хамааран “боловсрол”, “мэргэжлийн карьер”, “жилийн орлого” гэх мэт шалгуур үзүүлэлт тус бүрийг оноогоор тооцон дүгнэдэг. Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт өргөдөл гаргаж, энэхүү оноо нь нийт 70-аас дээш болсноор “Өндөр түвшний гадаадын боловсон хүчин” хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн хүн дараах давуу эрхийг эдэлнэ.

- Олон төрлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх
- 5 жилийн хугацаагаар оршин суух
- Байнгын оршин суух зөвшөөрөл авах шаардлагуудын доторх Японд амьдарсан жилтэй холбоотой шаардлагыг хөнгөвчлөх.м.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

https://www.moj.go.jp/isa/publications/materials/newimmiact_3_index.html



2023 оны дөрөвдүгээр сард "Японы тусгай, өндөр ур чадвартай мэргэжилтэнд зориулсан систем" (J-Skip) хэмээх шинэ тогтолцоог нэвтрүүлсэн юм. Өргөдөл гаргагчид эрдмийн зэрэг эзэмшсэн байдал, мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагад нийцсэн, жилийн орлогын заасан дүнгээс өндөр орлоготой тохиолдолд "тусгай, өндөр ур чадвартай мэргэжилтэн" хэмээн тооцогдох ба нэмэлт давуу эрх эдлэх боломжтой. Энэ нь дээрх оноонд тулгуурласан, өндөр ур чадвартай гадаадын мэргэжилтэнд зориулсан тогтолцооноос тусдаа тогтолцоо юм.

Дараах URL-с дэлгэрэнгүй үзнэ үү:

https://www.moj.go.jp/isa/publications/materials/nyuukokukanri01_00009.html



3

Японд дахин нэвтрэх зөвшөөрөл (Тухайн оршин суух зөвшөөрлөөрөө Японд дахин нэвтрэх)

Японоос гарахдаа Японд дахин нэвтрэх зөвшөөрөл авсан бол, зөвшөөрөгдсөн хугацаанаас хэтрээгүй тохиолдолд, одоо эзэмшиж байгаа оршин суух зөвшөөрөл, оршин суух хугацааны дагуу Японд дахин нэвтрэх боломжтой.

(1) Тусгай Японд дахин нэвтрэх зөвшөөрөл (1 жилийн дотор Японд буцаж ирэх тохиолдолд)

Оршин суугчийн үнэмлэх болон хүчинтэй гадаад паспорттой хүн Япон улсаас гараад 1 жилийн дотор (оршин суух хүчинтэй хугацаа нь 1 жилээс бага бол оршин суух хугацаа дуусах хүртэл) Японд буцаж ирэх тохиолдолд, урьдчилан Гадаадын иргэн харьяатын газраас Японд дахин нэвтрэх зөвшөөрөл авах шаардлагагүй. Япон Улсаас гарах үед дахин нэвтрэх зорилгоор “ED карт”-ыг бөглөн, паспортын (мөн оршин суух үнэмлэх) хамтаар хилийн байцаагчид үзүүлнэ үү.

(2) Японд дахин нэвтрэх зөвшөөрөл (1 жилээс дээш хугацаагаар Японоос гарах тохиолдолд)

Урьдчилан ойролцоох орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт өргөдөл гаргаж, Японд дахин нэвтрэх зөвшөөрөл авснаар, одоо эзэмшиж байгаа оршин суух зөвшөөрөл болон оршин суух хугацааны дагуу Японоос гараад дахин нэвтэрч болно. (Хамгийн уртдаа 5 жил байна. Оршин суух хугацаа нь 5 жилээс бага бол хүчинтэй хугацаа дуусах хүртэл) Япон Улсаас гарах үед дахин нэвтрэх зорилгоор “ED карт”-ыг бөглөн, паспортын (мөн оршин суух үнэмлэх) хамтаар хилийн байцаагчид үзүүлнэ үү.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-5.html>



4

Дүрвэгч болон бусад иргэнийг хүлээн зөвшөөрөх журам

Япон Улс нь Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц болон хавсралт болох Дүрвэгсдийн эрх зүйн байдалтай холбоотой протоколын гишүүн улс бөгөөд тус конвенцид тодорхойлсон дүрвэгч болон Цагаачлалын хяналтын тухай хуульд заасны дагуу дүрвэгчийн шаардлагад нийцэхгүй боловч олон улсын хамгаалалт шаардлагатай иргэнийг нэмэлт хамгаалалт олгогдох хүнээр хүлээн зөвшөөрдөг. Япон Улс нь дүрвэгсэд болон нэмэлт хамгаалалт шаардлагатай хүмүүст шуурхай, найдвартай хамгаалалт үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд тууштай байна.

4-1

Дүрвэгчийн тодорхойлолт

Дүрвэгчийн конвенцийн 1-р зүйл эсвэл Дүрвэгчийн статусын протоколын 1-р зүйлд заасны дагуу Дүрвэгчийн конвенцид хамрагдах дүрвэгчийг дараах байдлаар тодорхойлдог.

- Арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, тодорхой нийгмийн бүлэглэлийн гишүүн байх эсвэл улс төрийн үзэл бодлоосоо шалтгаалан дарамт шахалтад өртөх аюултай хэмээн үзсэн хангалттай үндэслэл бүхий айдастай байгаагийн улмаас, харьяа улсаас гарч явсан иргэн бөгөөд тухайн харьяа улсаас хамгаалалт авах боломжгүй эсвэл түүнийг хүсэхгүй хүн гэх мэт

4-2

Нэмэлт хамгаалалтад орох иргэний тодорхойлолт

Нэмэлт хамгаалалтад хамрагдах хүнийг дараах байдлаар тодорхойлно.

- Дүрвэгсдийн конвенцийн дагуу (4-1-д заасны дагуу) дүрвэгчид хамаарахгүй боловч, уг конвенцийн “гарал угсаа, шашин шүтлэг, иргэншил, тодорхой нийгмийн бүлэгт хамаарах байдал, эсхүл улс төрийн үзэл бодлын улмаас хавчигдах, мөрдөгдөх” эрсдэлд өртөхөөс бусад бүх шаардлагыг хангасан хүн байх.

4-3

Дүрвэгчээр тогтоолгох эсвэл нэмэлт хамгаалалтад хамрагдах эрх зүйн шаардлагын тухай өргөдөл

- Дүрвэгчээр тогтоолгох эсвэл нэмэлт хамгаалалтад хамрагдах эрх зүйн шаардлагын тухай өргөдөл гэдэг нь эх орноосоо зугтан гарч ирсэн дүрвэгчийг (4.1- ээс үзнэ үү) Япон улсаас хамгаалалт хүсэхэд зориулсан тогтолцоо юм. Тус өргөдлийг Японд байгаа гадаад хүн гаргах боломжтой. Дүрвэгчээр тогтоолгосон гадаадын иргэнд “Дүрвэгчээр тогтоолгосон үнэмлэх”, нэмэлт хамгаалалтад хамрагдсан иргэнд нэмэлт хамгаалалтад хамрагдах эрх зүйн шаардлагыг хангасныг гэрчлэх үнэмлэх олгоно. Аль ч тохиолдолд ерөнхий журмын дагуу “Урт хугацааны оршин суугч”-ын оршин суух зөвшөөрлийг олгодог.
- Дүрвэгчээр тогтоолгосон гадаадын хүн өргөдөл гаргасны үндсэн дээр паспортын оронд онгоцоор зорчиход хэрэглэх Дүрвэгчийн аяллын гэрчилгээ авч болно.
- Дүрвэгч болон нэмэлт хамгаалалтад хамрагдсан гадаадын иргэн болон түүний гэр бүлийн гишүүд нь япон хэлний болон аж төрөх ахуй орчны тухай сургалт, ажил зуучлал зэрэг “Урт хугацааны оршин суугчийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдах боломжтой.

Дараах URL-с дэлгэрэнгүй үзнэ үү:

<https://www.moj.go.jp/isa/applications/procedures/16-6.html>



4-4

Дахин шалгуулах хүсэлт

Дүрвэгчээр тогтоолгох эсвэл нэмэлт хамгаалалтад хамруулахаас тогтоолгохыг татгалзсан шийдвэрт гомдолтой байгаа гадаадын иргэн нь, Хууль зүйн сайдад хандан дахин шалгуулах хүсэлт гаргаж болно.

Хууль зүйн сайд дахин шалгуулах хүсэлтийн дагуу шийдвэр гаргахдаа, хууль болон олон улсын харилцаа зэргийн мэдлэгтэй Дүрвэгч шалгах зөвлөх мэргэжилтний саналыг сонсно.

Дэлгэрэнгүйг дараах вэб сайтаас лавлана уу.

Дахин шалгуулах хүсэлтийн тухай

https://www.moj.go.jp/isa/refugee/procedures/nanmin_00001.html#midashi04



5

Албадан гаргах үйл ажиллагааны тухай

5-1

Албадан гаргах үндсэн шалтгаан

- Оршин суух зөвшөөрлийн хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд (1 өдөр өнгөрсөн ч хууль бусаар оршин суусан гэж үзэн, албадан гаргахыг анхаарна уу)
- Зөвшөөрөлгүйгээр оршин суух зөвшөөрлөөс гадуур үйл ажиллагааг явуулах болон тэрхүү үйл ажиллагаанаас орлого олох, цалин авах
- Ямар нэгэн төрлийн эрүүгийн шийтгэл оногдуулсанвсан тохиолдолд

5-2

Албадан гаргах болсон тохиолдолд

Албадан гаргасан тохиолдолд үндсэндээ 5 болон 10 жилийн турш Японд нэвтрэх эрхгүй болно. Мөн ямар нэгэн эрүүгийн хэргийн ял шийтгэл авч албадан гаргасан тохиолдолд, журмын дагуу Япон улсын хилээр дахин нэвтрэх эрхгүй болно. Албадан гаргах шийдвэр эцэслэн гарсан хэдий ч, хэрэв тухайн гадаадын иргэн өөрийн зардлаар сайн дураар Япон Улсаас гарсан бол түүний дахин нэвтрэхийг хориглох хугацааг хүсэлт гаргаснаар нэг жил болгон бууруулах боломжтой.

5-3

Японоос гарах тушаалын тогтолцоо

Хууль бус оршин суугч нь доорх заалтуудад бүрэн хамаарагдаж байвал цагдан хоригдохгүйгээр хялбар бүртгэл хийх замаар Японоос гарах боломжийг олгох тогтолцоо юм.

Японоос гарах тушаалын дагуу хилээр гарсан тохиолдолд, журмын дагуу 1 жилийн хугацаанд Япон улсын хилээр нэвтрэх боломжгүй болно.

Японоос гарах тушаалын тогтолцоонд хамрагдах нөхцөл

Японоос гарах тушаалын тогтолцоонд хамрагдахад дараах нөхцлийг хангах хэрэгтэй.

(1) Дараах (а) эсвэл (б) нөхцөлийн аль нэгийг хангасан байх.

(а) Зөрчлийн талаарх шалгалт эхлэхээс өмнө гадаадын иргэн нь сйн дураараа Япон Улсаас гарах зорилгоор орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт өөрийн биеэр очсон байх

(б) Зөрчлийн талаарх шалгалт эхэлсний дараа Гадаадын иргэн харьяатын газрын байцаагч зөрчилтэй болох мэдэгдэл өгөхөөс өмнө, гадаадын иргэн нь Япон Улсаас даруй гарах хүсэлтэй байгаагаа Гадаадын иргэн харьяатын газрын хяналтын байцаагч эсвэл хамгаалалтын ажилтанд мэдэгдсэн байх

(2) Хууль бусаар хугацаа хэтрүүлэн оршин сууснаас өөр албадан гаргах үндэслэлгүй байх

(3) Гадаадын иргэн нь хулгай зэрэг тодорхой нэг гэмт хэргийн улмаас Япон Улсад шорон, засан хүмүүжүүлэх газарт хоригдох ял эдлээгүй байх



- (4) Гадаадын иргэн нь өмнө нь огт албадан гаргуулж байгаагүй, мөн Япон Улсаас албадан гаргах шийдвэрээр гарсан түүхгүй байх
- (5) Гадаадын иргэн нь нэн даруй Япон Улсаас гарах төлөвтэй байх

5-4**Оршин суух тусгай зөвшөөрөл**

Албадан гаргах процедур явагдаж байгаа хэдий ч тухайн гадаад иргэний Япон Улсад суурьшсан байдал, , гэр бүлийн нөхцөл зэргийг нь харгалзан үзэж, Хууль зүйн сайдаас оршин суух зөвшөөрлийг тусгайлан олгох тохиолдол байдаг.

6

Японд орж гарах, оршин суух зэрэг бүртгэлүүдийн талаар лавлах газрууд

Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газар

Саппорогийн Гадаадын иргэн харьяатын газар	Саппорогийн Засгийн газрын нэгдсэн III байр 〒060-0042 Hokkaido Sapporo-shi Chuo-ku Oodoorinishi 12	0570-003259 (IP утас болон гадаадаас: 011-211-5701)
Сэндайгийн Гадаадын иргэн харьяатын газар	Сэндайгийн Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын нэгдсэн II байр 〒983-0842 Miyagi-ken Sendai-shi Miyagino-ku Gorin 1-3-20	Утас 0570-022259 (IP утас болон гадаадаас: 022-256-7025)
Токиогийн Гадаадын иргэн харьяатын газар	〒108-8255 Tokyo-to Minato-ku Minatominami 5-5-30	Утас 0570-034259 (IP утас болон гадаадаас: 03-5796-7234)
Токиогийн Гадаадын иргэн харьяатын газар Ёцуяагийн салбар алба	〒106-004 Tokyo-to Shinjuku-ku Yotsuya 1-6-1 Yotsuya Tower 13 болон14 давхарт	Утас 0570-011000
	Оршин суух статусын бүртгэлийн газар	Харьяалагдах байгууллага зэргийг бүртгүүлэх, харьяалагдах байгууллагаас мэдүүлэх
	Онлайн шалгалтын хэлтэс	Оршин суугчид онлайнгаар бүртгүүлэх
	Мэдээлэл хяналтын алба	Хяналт шалгалтын бүртгэл хөтлөх
Нарита нисэх онгоцны буудлын салбар	Нарита нисэх онгоцны буудлын 2-р терминалын 6 давхарт 〒282-0004 Chiba-ken Narita-shi Furugome 1-1	Утас 0476-34-2222 (үндсэн дугаар) Утас 0476-34-2211
Ханэда нисэх онгоцны буудлын салбар	〒144-0041 Tokyo-to Ota-ku Haneda-kuko 2-6-4 Haneda Airport CIQ Bldg	Утас 03-5708-3202
Ёкохамагийн салбар	〒236-0002 Kanagawa-ken Yokohama-shi kanazawa-ku Torihama-cho 10-7	Утас0570-045259 (IP утас болон гадаадаас: 045-769-1729)
Нагояагийн Гадаадын иргэн харьяатын газар	〒455-8601 Aichi-ken Nagoya-shi Minato-ku Shoho-cho 5-18	Утас 0570-052259 (IP утас болон гадаадаас: 052-217-8944)
Чюүбү нисэх онгоцны буудлын салбар	〒479-0881 Aichi-ken Tokoname-shi Centrair 1-1 CIQ Bldg 3F	Утас 0569-38-7410 (үндсэн дугаар)
Оосакагийн Гадаадын иргэн харьяатын газар	〒559-0034 Osaka-fu Osaka-shi Suminoe-ku Nankou Kita 1-29-53	Утас 0570-064259 (IP утас болон гадаадаас: 06-4703-2050)
Кансай нисэх онгоцны буудлын салбар	〒549-0011 Osaka-fu Sennan-gun Tajiri-cho Senshu-Kukochu 1	Утас 072-455-1453 (үндсэн дугаар)
Кообэгийн салбар	Кообэгийн засгийн газрын нэгдсэн байр 〒650-0024 Hyogo-ken Kobe-shi Chuo-ku Kaigan-doori 29	Утас 078-391-6377 (үндсэн дугаар)
Хирошимагийн Гадаадын иргэн харьяатын газар	Хирошимагийн Хууль зүйн ерөнхий газрын байр 〒730-0012 Hiroshima-ken Hiroshima-shi Naka-ku Kami-hachobori 2-31	Утас 082-221-4411 (үндсэн дугаар)
Такамацүгийн Гадаадын иргэн харьяатын газар	Такамацү Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын хамтарсан байр (Тамгын газар, Гүйцэтгэх хэлтэс) 〒760-0033 Kagawa-ken Takamatsu-shi Marunouchi 1-1	Утас 087-822-5852 (үндсэн дугаар)
Такамацү бүс нутгийн цагаачлалын үйлчилгээний товчоо Хаманочо салбарын оффис	Хаманомачи салбар (Хяналтын тасаг) 〒760-0011 Kagawa-ken Takamatsu-shi Hamanochi, 72-9	Утас 087-822-5851 (үндсэн дугаар)
Фүкүокагийн Гадаадын иргэн харьяатын газар	Фүкүокагийн 1-р хууль зүйн ерөнхий газрын байр 〒810-0073 Fukuoka-ken Fukuoka-shi Chuo-ku Maizuru3-5-25	Утас 092-717-5420 (үндсэн дугаар)

Нахагийн салбар	Нахагийн 1-р бүсийн засгийн газрын нэгдсэн байр 〒900-0022 Okinawa-ken Naha-shi Hikawa 1-15-15	Утас 098-832-4185 (үндсэн дугаар)
Зүүн Японы Гадаадын иргэн харьяатын төв	〒300-1288 Ibaraki-ken Ushiku-shi Kuno-cho 1766-1	Утас 029-875-1291 (үндсэн дугаар)
Оомүра Гадаадын иргэн харьяатын төв	〒856-0817 Nagasaki-ken Omura-shi Kogashima-cho 644-3	Утас 0957-52-2121 (үндсэн дугаар)

Гадаад оршин суугчдыг дэмжих төв

Гадаад оршин суугчдыг дэмжих төв	〒160-0004 Tokyo-to Shinjuku-ku Yotsuya 1-6-1 Yotsuya Tower 13F	TEL 0570-011000 (IP утас болон гадаадаас: 03-5363-3013)
----------------------------------	---	---

Гадаадын оршин суугчдын мэдээллийн нэгдсэн төв

Биечлэн зөвлөгөө авах	Дээр дурдсан Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газар салбаруудын хяналтын алба. (Токиогийн Гадаадын иргэн харьяаын Ёцуя салбар, Нисэх онгоцны буудлын салбарууд, Гадаадын иргэн харьяатын хяналтын төвүүдээс бусад)	
Утсаар зөвлөгөө авах	Утас 0570-013904 (IP утас/ гар утас /гадаадаас; TEL 03-5796-7112)	

7 Гадаадын иргэн харьяатын газраас түгээх мэдээлэл

7-1

Гадаадын иргэн харьяатын газрын албан ёсны вэб хуудас

Гадаадын иргэн харьяатын газрын албан ёсны вэб хуудас дээр Япон оршин суух зөвшөөрлийн мэдүүлгийг хэрхэн өгөх тухай зэргийг тайлбарлаж байна. Япон хэлнээс гадна бид 100 гаруй хэлээр машин орчуулсан мэдээллээр хангадаг.

Гадаадын иргэн харьяатын газрын албан ёсны вэб хуудас

<https://www.moj.jp/isa/index.html>

* Оршин суух журамтай холбоотой төлбөр, хураамжийг 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс шинэчилнэ.

https://www.moj.jp/isa/01_00518.html



7-2

Гадаадын иргэн харьяатын газрын албан ёсны нийгмийн сүлжээ г.м.

Гадаадын иргэн харьяатын газар нь шинэ тогтолцооны талаар мэдээлэл өгөх, мөн гадаадын иргэдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй мэдээллийг түгээх зорилгоор төрөл бүрийн нийгмийн сүлжээ зэрэг сувгийг нээн ажиллуулж байна.

Гадаадын иргэн харьяатын газрын X хаяг (хуучин Twitter):

https://x.com/MOJ_IMMI



Гадаадын иргэн харьяатын газрын Фэйсбүүк хаяг:

<https://www.facebook.com/ImmigrationServicesAgency.MOJ/>



Гадаадын иргэн харьяатын газрын Инстаграм хаяг:

https://www.instagram.com/isa__Japan/



И-мэйлээр ашигтай мэдээлэл түгээх үйлчилгээ

<https://www.moj.go.jp/isa/publications/publications/mail-service.html>



Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газруудын X хаягууд (хуучнаар Twitter) үйлчилгээний лангуунууд хэр завгүй байгаа талаар мэдээлэл өгдөг.

Орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газруудын хаягууд:

https://www.moj.go.jp/isa/publications/publications/nyuukokukanri01_00184.html



7-3

Япон Улсад амьдарч буй гадаадын иргэдийг дэмжих портал сайт

Энэхүү вэбсайт нь Япон Улсад гадаадын иргэд аюулгүй, тав тухтай амьдрахад шаардлагатай болон чухал мэдээллийг олон хэлээр хүргэдэг мэдээллийн эх сурвалж юм.

Тус сайтаас Японы Засгийн газраас гаргасан мэдээллийг олон орны хэлээр хүлээн авах боломжтой.

Япон Улсад амьдарч буй гадаадын иргэдийг дэмжих портал сайт:

<https://www.moj.go.jp/isa/support/portal/index.html>



7-4

Хэрхэн амьдрах талаарх танилцуулга видео

Япон Улсад амьдрахаар төлөвлөж буй болон одоо амьдарч байгаа гадаадын иргэдэд зориулан, Япон дахь амьдралыг илүү саадгүй таатай, ойлгомжтой болгоход туслах зорилгоор хэрхэн амьдрах талаар чиглүүлэх танилцуулга видео бэлтгэсэн болно.

Энэхүү видеонд Япон Улсад амьдрахад хэрэгтэй үндсэн мэдээлэл болон дүрэм журмууд (жишээлбэл: амьдралын хэв маяг, ажил хөдөлмөр, татвар зэрэг)-ын тухай олон орны хэлээр танилцуулж байна.

Хэрхэн амьдрах талаар танилцуулга видео:

https://www.moj.go.jp/isa/support/coexistence/04_00078.html

